

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын

2021 оны 4 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 4 сарын 23-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Дөрөвдүгээр сард 149 албан бичиг бүртгэгдсэн бөгөөд үүнээс хугацаатай 33 албан бичгийг хугацаанд нь холбогдох албан тушаалтан, байгууллагад хүргүүлсэн. Ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж - 51 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2021 оны 4 сарын байдлаар шинээр төрсөн-35 (үүнээс ковидтой холбоотой хугацаа хэтэрсэн төрөлт -1), ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-1, нас барсан- 12, шинээр гэрлэсэн-18, цахим иргэний үнэмлэх захиалсан– 22, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 31, эцэг, эх тогтоолгосны бүртгэл – 4 тус тус бүртгэгдсэн байна. 2020 оны 09 сарын 01-ээс 12 сарын 31 хүртэлх төрсний, гэрлэсний, нас барсны нотлох баримтыг файл үүсгэн бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Орон нутгийн орлого нийт 24856,5 мян төгрөг орохоос 11403,0 мян төгрөг орж орлогын төлөвлөгөө 45,8 хувийн биелэлттэй байна. Энэ нь уул уурхайн компаниас гэрээний дагуу орох орлого тасарсантай холбоотой юм. 2021 оны 04 дүгээр сараас эхлэн батлагдсан төсөвт зардал 50 хувиар хасагдаж ирсэн байна. Хэдийгээр Төрийн албан хаагчид хори цээрийн дэглэм байгаа ч гэсэн гэрээс ажлаа гүйцэтгэх боломжоор ханган цалин шимтгэлийг бүрэн олгоод байна. Шилэн дансанд 2020 оны ТЭЗ-ийн санхүүгийн тайлан, аудитийн дүгнэлт байршуулсан. Мөн статистикийн 1-р улирлын мэдээ тайланг явуулсан байгаа.

Худалдан авах ажиллагааны талаар:

Сумын хэмжээнд халуун усны барилгад нээлттэй тендер шалгаруулах үнэлгээний хороо, Чийрэгжүүлэлтийн төв байгуулах үнэлгээний хороог тус тус байгуулав. Одоогоор тендерийг зарлаагүй байна. Аймгаас эрх шилжиж ирэх Жавхлант багийн төвийн барилгыг өндөр хүчдэл холбох тендерийн хороог байгуулах зураг төсвийг судлаж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль орчины чиглэлээр:

Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай болон албан байгууллага аж ахуй нэгжүүдийн гадна талбайд 2 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийг 23100 м2 талбайд мал эмнэлэгийн тасагтай хамтран хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 03-ны өдрийн 211 дүгээр тогтоолын дагуу ус, дулааны үнийг төлбөрөөс чөлөөлсөнтэй холбогдуулан 2020 оны 3 дугаар сарын усны төлбөр болох 1369800 төгрөгийг сумын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэнийг 4 газарт буцаан олгосон.

“Агаарын бохирдолыг бууруулах нь” уурын болон усан халаалтын зуух үйлдвэрлэгч, ашиглагч нарт зориулсан салбарын дарга эрхлэгч нарт зориулсан сургалт, Мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нь сургалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт сургалтанд төсөвт байгууллагын дарга эрхлэгч нартай хамт хамрагдсан.

Газар зохион байгуулалт:

Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авахаар материал бүрдүүлж байгаа 3 иргэнд кадастрын зураг болон холбогдох бусад мэдээллийг бүрдүүлж өгөв.

ЗДТГазрын газар эзэмших гэрчилгээтэй /Жавхлант, Дэлгэр, Тэгш/ 3 газрын газрын гэрчилгээг шинэчилж гаргасан. Үүнд:

1. Үүний тулд улсын бүртгэлрүү дундын мэдээллийн сангаар холбогдох материалуудыг скайнердаж явуулан Э дугаар авсан.
2. Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн нэхэмжлэхийг газрын цахим програмаас гаргаж өгсөн.
3. Гэрчилгээний үнийн байгууллагын нэхэмжлэх үүсгэж өгсөн.

Эзэмших, ашиглах газрын эрх үүссэн 39 нэгж талбарын газрын төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэн холбогдох газруудад нь хүргэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

ХАА-1 мэдээг цаг тухай бүрд нь илгээв. Сумын хувьд 106959 хээлтэгчээс 69409 нь буюу 64.9% нь төллөөд байна. Үүнээс ингэ-136, гүү-2396, үнээ-2416, эм хонь-41590, эм ямаа- 22871 төллөөд байна. Нийт 69415 төл хүлээж авснаас төлийн бойжуулалт 100%-тай байна.

ХАА-2 мэдээг цаг тухай бүрд илгээв. 2021 оны 4 сарын байдлаар Том малын зүй бус хорогдол 324 /толгой/ гарсан байна.

Хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд сэг зэм устгалыг Баян багийн “Тунгаа” хэмээх газар байрлах Ц.Мөнхбатын өвөлжөө дээр 8-н жил хуримтлагдсан малын сэг зэгийг хогийн машинаар 2 удаа сумын төвийн нэгдсэн хог руу зөөж цэвэрлэв.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

2021.04.22-ны байдлаар “Гүн Хүсэл”, “Хишиг”, “Өгөөж”, “Дэлгэрэх”, “Эрдэнэ-Оргих”, “Баян” гэсэн 6 аж ахуйн нэгжүүд дараах хүнсний бүтээгдэхүүний нөөцтэй байна.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	18 тн
Гурилан бүтээгдэхүүн	185 ш
Будаа	320 кг
Хуурай/Шингэн сүү	495ш
Өндөг	920ш
Ургамлын тос	156ш
Төмс	200кг
Хүнсний ногоо	135кг
Элсэн чихэр	240кг
Давс	194кг
Савласан ус	313ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, хүнсний тээвэрлэлт хэвийн явагдаж байна. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хөдөлгөөний хязгаарлалт хийсэнтэй холбогдуулан Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж иргэн айл өрхөд хүнс болон эмийн үйлчилгээг хүргэх арга хэмжээг зохион байгуулж хүргэлтээр 09:00-19:00 цагийн хуваарийн дагуу халдвар хамгааллын дэглэмээ мөрдөн аж ахуйн нэгжүүд хүргэлт үйлчилгээг явуулж байна.

Түлшний нөөцийн хувьд:

№	Байгууллагын нэр	А-80	А-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	18тн 600л	5тн 200л	13тн 800л

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг өмнөх сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр	2021 оны 3 сарын 25 байдлаар	2021 оны 4 сарын 14 ны байдлаар
---	--------------------	---------------------------------	------------------------------------

1	гурил	Дорнод дээд	36000	36000
		УБ 1-р зэрэг	35000	37000
		Дорнод 2-р зэрэг	27000	29000
2	Цагаан будаа		2500	2800-3000
3	Шингэн сүү		3400	3600-3700
4	Хуурай сүү		5000-9500	5000-10000
5	Элсэн чихэр		2500	2800-3000
6	Ургамлын тос		4800	4800-5200
7	Өндөг		700	700
8	Төмс		1800	1500
9	Хүнсний ногоо	Сонгино	3000	3500
		Байцаа	2000	2500
		Лууван	2000	2500
		Сармис	2500	2500
10	Давс		1000-1100	1000-1500
11	Савласан ус		600-3500	600-4000

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг 2021оны 4сарын 11 өдөр аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт мэдэгдэл хүргүүлж, хууль тогтоомж зөрчих, мэдэгдлийн хэрэгжилтийг хангахгүй зөрчил гаргавал Зөрчлийн тухай хуулийн дагуу 5.13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага оногдуулахыг мэдэгдсэн.

Коронавируст халдвар цар тахлын батлагдсан тохиолдол гарсантай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, Аж ахуйн нэгж худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулан, үйл ажиллагаанд нь хяналт, тавьж мэргэжлийн байгууллагаас өгч байгаа заавар зөвлөмжийг чанд мөрдөж, иргэдэд бараа үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг сахин үйлчилгээ явууж байгаад хяналт тавин ажиллаа.

- Бараа бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээ, хүнсний дэлгүүрийн үйлчилгээнд мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж зөвлөгөөг цахимаар болон цаасаар хүргэн ажиллаж байна.
- Халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж халдвар хамгааллын дэглэмээ сахин үйлчилгээ явуулахыг шаардаж байна.

Сумын стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах харилцааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээг 2021 оны 4 сарын 8 өдөр “Гүнхүсэл”, “Өгөөж”, “Эрдэнэзоргих”, гэсэн 3 аж ахуй эрхлэгч нартай хүнсний нөөц бүрдүүлэх гэрээг хамтарч байгуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2021.4.10-ны өдрийн А/217 дугаар захирамжаар “2021.4.25-ныг хүртэл архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхгүй байхыг хориглосон” захирамжийн дагуу 2021.4.15-ны өдөр дэлгүүрүүдийн согтууруулах ундааны тоо ширхэгийн хэмжээг авч бүртгэл хийх, лацдах арга хэмжээг хэсгийн цагдаа Анхбаяр, Олон нийтийн цагдаа Э.Хатантөмөр нартай хамтарч явуулсаны үр дүнд тусгай зөвшөөрөлтэй 4 дэлгүүрийн 410 ширхэг архи, согтууруулах ундааг лацдав.

2021.03.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 248,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

- Хэвийн зээлтэй - 10 зээлдэгчийн 70,000,000 төгрөг,
- Эргэлзээтэй зээлтэй /181-360хоног/- 5 зээлдэгчийн 47,000.000 төгрөг
- Муу буюу чанаргүй зээлтэй /360≥/- 15 зээлдэгчийн 131,800,000 төгрөг
- 7 зээлдэгчийн 48,287,470, төгрөг эргэн төлөгдөж хаагдсан.

2.1.1. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 63.7% байна.

Зсарынн байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 7,000,000 төгрөг орж ирсэн.

2.1.2. Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас чиглэл болгосны дагуу сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг зохион байгуулж, аудитын дүгнэлтийг 2021 оны 04 сарын 01-ний дотор хүргүүлсэн.

Мал эмнэлэгийн чиглэлээр:

2021 оны 3 сарын 26 нд сумын Засаг даргын тамгын газрын, газрын даамал, байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран Жавхлант багийн нутгийн засмал замын ойр орчимд хаясан 45 мал амьтны сэг зэм, хогийг түүж цуглуулан устгалын цэгийн нүхэнд хийж булж устгах ажлыг зохион байгууллаа. Уг ажилд Сун хун голд уурхайн машин техникийг дайчлан ажилласан.

2021 оны 3 сарын 31 нд аймгийн мал эмнэлгийн газарт хувийн мал эмнэлгийн малын эмч, санитарч, туслах ажилтан жолооч нарын судалгааг гаргаж хүргүүлсэн.

Дэлхий нийтэд тархаад байгаа короно вируст цар тахлын байдалтай холбогдуулан 2021 оны 4 сарын 5, 4 сарын 19, 20 ний өдрүүдэд Засаг даргын тамгын газрын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран халдваргүйтгэлийн арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Уг арга хэмжээнд хяналтын 4 пост, нийтийн эзэмшлийн зам талбай, авто зогсоол, шатхуун түгээх станц, албан байгууллага, аж ахуй нэгжийн 14400 м², зоорь агуулахын 500 м², байр орон сууцны 3600 м², муу усны нүх жорлонгийн 1600м², сумын төвийн болон голомтын бүсийн айл өрхийн 25 худаг уст цэгийн 3000 м² талбай нийт 23100 м² талбайд эцсийн халдваргүйтгэл хийсэн.

2021 оны 4 сарын 15 нд аймгийн Мал эмнэлгийн газарт ариутгал халдваргүйтгэлийн эмийн бодис, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Мал эмнэлгийн ерөнхий газраас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд хамрагдсан. Мөн малын хорогдол, мал амьтны хүүр сэг зэм устгал, халдваргүйтгэлийн мэдээг 7 хоногийн 4 дэхь өдөр бүр аймгийн мал эмнэлгийн газарт хүргэж ажиллахын зэрэгцээ сэг зэм устгал, халдваргүйтгэлийн нэгдсэн тайланг хүргүүлэхэд бэлэн болоод байна.Тайлангийн хугацаанд сумын Засаг даргын тамгын газраас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, аймгийн Мал эмнэлгийн газраас ирсэн 4 төрлийн хариутай мэдээ судалгаа ирсний хариуг хугацаанд барагдуулж ажиллаа.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгчаар бүртгэсэн 34 иргэнийг сэргээсэн.

2021 оны 04 сард Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд жирэмсэн эхийн тэтгэмжинд 4 иргэн, цалинтай эхийн тэтгэмжинд 4 иргэнийг бүртгэсэн. Хүнсний талоны 42 өрхөөс 27 өрхийн хүнс тэжээлийг олгосон.Шинээр төрсөн 2 хүүхдийн бичиг баримтыг хүлээн авч бүртгэсэн. 04-р сарын 21-ны өдөр хөдөлмөр аюулгүй байдлын сургалт зөвлөгөөн оролцсон.

Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 145172.7 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -124379.0мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 15862.5 мян төг

- ЭМДаатгалын шимтгэлд- 4931.2 мян төг орлоо.

Хэлтсээс 390000.0мян төгрөгийн санхүүжилт авч 450 тэтгэвэр авагчдад 637233.1мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 156 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 15862.5 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 120 даатгуулагчийг даатгаж 4931.2 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -18, тахир дутуугийн тэтгэвэр-1, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -2 нийт 21 тэтгэвэр, 1 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн, 4 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоогоод байна.

Оршуулгын тэтгэмж 6 тэтгэвэр авагчдад 6000.0 мян төгрөг жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 8 даатгуулагчдад 18146.4 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

2020 оны харилцах, тооцооны хуудас тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-21 ,тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-2 , тэтгэмж-8, ажилгүйдлын тэтгэмж-1 малчнаар ажилласан жил тогтоолгох-6 нийт 43 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 338 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна..

Нийгмийн бодлогын чиглэлээр:

Сумын нутаг дэвсгэрт короновирусын халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор батлагдсан тохиолдол, ойрын олон дам хавтлуудыг илрүүлэх зорилгоор шаардлагатай өрх иргэдийн мэдээллийг нэгтгэн гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Эрүүл мэнд:

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1734
2	Амбулаторийн үзлэг	796
3	Гэрийн дудлага	169
4	Алсын дуудлага	103
5	Артерийн даралт	459
6	Чихрийн шижин	586

7	Хөхний үзлэг	381
8	Эсийн шинжилгээ	9
9	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	108
10	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	113
11	Гэрийн тусгаарлалтад байгаа	18
12	Гэрийн ажиглалтад байгаа	6

Ерөнхий боловсролын сургууль :

- Дунд ангийн 5 багш 6-9-р ангийн сурагчдад ангийн группээр цахим хичээлийг зааж байна.
- Сургуулийн ХХБ-аас 2 хүүхдийн гэрийн эргэлт хийв.
- Сургуулийн нээлттэй группэд дараах 3 чиглэлийн дагуу нийтлэлийн сэдэв мэдээллийг хийж нэгтгэлээ. Мэдээллийг нэгтгэснээр иргэд, сурагчид, багш нар мэдээллийг нийтлэлээс хугацаа шаардахгүйгээр харах боломжтой. Үүнд:Хүүхэд хамгаалал, Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлье, Эрүүл мэнд
- Машинт болон хөдөлгөөнт эргүүлд гарч байгаа багш ажилчдадаа хамгаалалтын хувцас бээлий өгсөн.
- Машинт эргүүлд өдөр, орой хуваарь гарган хоол хийж өгч байна.
- Багш ажилчдыг АНЭ-ийн дотор, мэдрэл, эхо оношилгоонд хамруулсан.
- Бага ангийн багш нар ажлын өдөр бүр 1 бодлого бодож, 3-р сард нийт 190 бодлого бодсон.
- Сургуулийн 437 хүүхдийн эрсдэлийн үнэлгээг АУБ нараар хийлгэж эрсдэлийг тогтоов.
- Аймгийн ОБГ-с сургуулийн эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх талаар 15 багш, ажилчдад сургалт зохион байгуулж, үүний үндсэн дээр эрсдэлээ тогтоон байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлууллаа.
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 14 шторк хийн байрлуулав.
- Багш нарт 2 таблет авч өгөв. ОНХС-н 45 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар МТКабинеттай боллоо. Кабинетын сандлын бүрээс, доторлогооны акустик хавтанг өөрийн төсөв, хандиваар хийлээ.

- БСУГ-аас бага ангийн монгол хэл, математик хичээлээр оношилгооны шалгалт авч анализ хийсэн. Мэргэжлийн багш нараас мэргэжил тус бүрээр шалгалт авсан.
- Багш ажилчдынхаа дархлааг дэмжиж 600 гаруй мян.төгрөгийн витагрипп, вит D авч өглөө.
- “Хашаандаа сайхан амьдаръя” уралдаанаас 8-р ангийн сурагч О.Болор-Эрдэнэ Тэргүүн байр, Цагаан зээрийг хайрлая эссэ бичлэгийн уралдаанд гадаад хэлний багш Ө.Алтанчимэг 2-р байр эзэллээ.
- "[#Ковид](#) ба хүүхэд хамгаалал" "[#Эрүүл](#) шүд- Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр, [#Онцгой](#) нөхцөл байдлын үед [#хүүхдийн](#) эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам, [#Хүүхдийн](#) эрхийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай ХНХС-ын 01 албан даалгавар, “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын "[#Гэр](#) бүлийн орчинд хүүхдийн [#аюулгүй](#) байдлыг хангах, [#болзошгүй](#) [#осол](#) гэмтэл, [#эрсдлээс](#) урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай хамтарсан удирдамж, "Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх нь" сэдвээр цахим сургалт зохион байгууллаа. Хүүхдийн хүмүүжил төлөвшил, хөгжил, хамгаалалд анги удирдсан багшийн үүрэг, оролцоо, хариуцлага сэдвээр Хүүхэд хүчирхийлэхийн эсрэг үндэсний хөдөлгөөний ерөнхий зохицуулагч, ХҮҮДД-ийн эрх хамгаалал төв ТББ, Үжин төвийнн захирал Д.Ундраагаас 27 багш, удирдах ажилтанд сургалт авч, зохион байгууллаа.
- Бага ангийн 10 багш, сургалтын менежер, байгалийн ухааны 2 багш “Эртэч багш” сургалтанд хамрагдаж байна:
- Ээлтэй бодлого-Эрсдэлгүй орчин-Эрчтэй зүтгэл аяны хүрээнд эрсдэлийг бууруулах зорилгоор сургуулийн дотор талыг шатанд зориулалтын резин наав.

Хүүхдийн цэцэрлэг:

1. Суманд “Ковид19” сэжигтэй тохиолдол илэрч 3-р сарын 29-нд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хаагдаж цахимаар хичээл сургалтын үйл ажиллагаа явагдаж хүүхдийн хамргдалт 78,3%-тай байна.
2. Багш нар хүүхдүүдтэйгээ байнга утасаар болон цахимаар холбогдон уялдаа холбоотой ажиллаж байна.

3. Бүлгийн багш нар хүүхдүүдээ цахимаар 15, цаасаар 212 ширхэг даалгаварыг хүргэсэн байна.
4. Эрхлэгч, багш, туслах багш ажилчид өөрсдийн ажил мэргэжилийн холбогдолтой, БМДИ-ээс цахимаар зохион байгуулсан сонголтот сургалтуудад хамрагдаж. Мөн туслах багш, ажилчид өөрийгөө хөгжүүлэх зорилгоор гар урлалын төрөлжсөн сургалтанд хамрагдаж 3-н тоорой, улаан малгайт зэрэг үлгэрийн баатаруудыг сүлмэлээр сүлжээд байна.
5. Ковид19 өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 1-р тун вакцинийг 18 багш ажилчид хамрагдаж 1 эмчийн заавараар 3 хүн жирэмсэн 81,8% нь хамрагсан
6. Эрэгтэй ажилчид хээрийн болон байнгийн эргүүлд эмэгтэй багш ажилчид хуваарийн дагуу 4-н зам дээр явган өдрийн эргүүлд гарч байна
7. Цахим хуудсанд багш ажилчид хуваарийн дагуу “Ковид19” болон эрүүл ахуй зөвлөмж-18, зөвлөгөө-15, уриалга-16 байршуулаад байна.
8. Ковид19” өвчинтэй холбогдуулан байгууллагын халдвар хамгааллын баг дотор гадна ариутгал халдваргүйтгэлийг анги, танхим, өрөө тасалагаанд “мансаржуулагч” ариутгал халдваргүйтгэлийг гадна, дотор орчинд хийлгэлээ.

Соёлын төв:

Байгууллагын цахим хуудас болон нийтийн номын сан хаягаар соёл өв уламжлалын мэдээлэл, өгүүллэг 13, тууж 2, Үлгэр 8-ыг нийтэлж 5963 хандалт авсан байна.

Соёлын биет бус өв тээгчдийн мэдээлэл болон тахилга шүтлэгт уул овоодын бүртгэлийг цахим бүртгэлд бүртгэж байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Засаг даргын тамгын газраас долоо хоногийн 1, 3, 5 дахь өдрийг “Хууль зүйн зөвлөгөө мэдээллийн өдөр” болгосон бөгөөд өөрсдийн болон бусад төрийн байгууллагын бэлгэтсэн хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн эх сурвалжийг дурдаж мэдээллийг “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар” гэсэн цахим хуудсаар тогтмол хүргэж байна. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй, мэдээллийг тогтмол хүргэж байхыг чухалчлан “Сүхбаатар аймгийн Уулбаян сумын албан ёсны мэдээ, мэдээллийн нэгдсэн групп”-ийг нээн түүгээр мэдээлэл хүргэж байна. 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн өдөр”-ийг тохиолдуулан “Гэр бүлийн тухай хууль”, Иргэний улсын бүртгэлийн тухай

хууль, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль” зэрэг хууль зүйн сурталчилгааны мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

Мөн Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эрх зүйн зөвлөгөө, мэдээллийн сайт e-khutuch.mn-ыг олон нийтэд сурталчилж, зөвлөгөө мэдээлэл авах боломжтой мэдээлэл нийтэллээ.

Төрийн албан хаагчдад мэргэжил, ур чадвар дээшлүүлэхэд чиглэсэн “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” сургалтад хамруулж байна. Одоогоор, тамгын газрын 7 албан хаагч хамрагдсан байна. Мөн төсөвт байгууллагын удирдах албан хаагчдыг хамруулж байна.

Тамгын газрын албан хаагчдыг долоо хоног бүрийн дөрөв дэх өдрийн мэдээллийн цагт долоо хоногт хийсэн ажил, цаашид хийх зүйлийн тухай илтгэл тавьж эхэлсэн боловч ковидтой холбоотойгоор түр зогссон байна.

Хууль зүйн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад Тамгын газрын дарга, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн нар 04 дүгээр сараас эхлэн суралцаж байна.

“Засгийн газрын хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарын нэгдсэн уулзалтын хүрээнд даалгасан ажлыг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр Засаг даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу тамгын газар болон бусад төсөвт байгууллагын албан хэрэг хөтлөлтийн байдалд үзлэг хийж, шалгалтыг хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн хариуцан зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргав.

Шинээр томилогдох дөрвөн багийн Засаг даргын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг авилгалтай тэмцэх газарт хүргүүлсэн.

Улсын Онцгой Комиссын даргын 2021 оны 03 сарын 03-ний өдрийн 18 дүгээр тушаалын хэрэгжилтийн биелэлтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1. “Ковид-19”-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах түүнд тавигдах шаардлагуудыг чиглэл чиглэлээр ангилж аж ахуйн нэгж, иргэнд хүргэж ажилласан.
2. Аж ахуйн нэгж, байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэнд “Амны хаалт тогтмол зүүх”, “Маскгүй хүнд үйлчлэхгүй” гэсэн шаардлагыг тавьж ажилласан.

3. “Эрдэнэоргих”, “Дэлгэр”, “Хишиг” гэсэн 3 аж ахуйн нэгжид “Зай барих”, “Амны хаалт зүүх”, тэмдэг зөвлөгөөг гарган өгч лангуу, хаалга мэдээллийн самбар дээр байрлуулсан.
4. Иргэн бүрийг өөрийн болон гэр бүлийн гишүүдээ болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, QR код уншуулах, амны хаалт зүүж, хоорондын зайгаа барьж үйлчлүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцохгүй байхыг зөвлөж байна.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар “Гэрийн тусгаарлалт, ажиглалад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэг” байгуулан хэсгийн ахлагчаар хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдэд зөвлөмж, баталгаажилтын хуудас, хууль, дүрмийг бэлтгэн өгч, өдөр бүр ярьж биеийн байдлыг үзэж байна. Өнөөдрийн байдлаар гэрийн тусгаарлалтад 18 иргэн, ажиглалтад 6 иргэн байна.

Тусгай дугаарын /98514040/ утасыг ажиллуулж иргэдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна.

2020 оны 4 сарын байдлаар хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг-1, танхайрах зөрчил-1 тус тус гарсан байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ